



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/180

Мандалговь

**Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “г”, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2-р багийн нутаг дэвсгэр “Сүмийн гадаах”-д байршилтай Алтангэрэлийн Эрдэнэбаатар (РД:ЗК68060314)-ийн өвөлжөөний зориулалттай 5000 м.кв (0.5 га) газрыг Лхаасүрэнгийн Мандахсүрэн (РД:ЗГ90012802)-д зориулалтын дагуу шилжүүлэн 8 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Л.Хулан)-д зөвшөөрсүгэй.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/42 дугаар захирамжийн хавсралтын 7 дахь хэсэг мөн газар эзэмших эрхийн 000475578 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ